



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 01 дүгээр сарын 10

Номгон

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл нь 2021 онд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 94, 2021 оны 16 дугаар тогтоолоор томилогдсон дарга, орон тооны Нарийн бичгийн дарга, гишүүд, нийт 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр Төрийн албаны тухай хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэр, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 94, 2021 оны 16 дугаар тогтоол /11 гишүүнтэй/

Салбар зөвлөлийн	Овог нэр	Албан тушаал
Дарга	Дашдонлогийн Энхсэргэл	Аймгийн ЗДТГ-ын дарга
Нарийн бичгийн дарга	Батбаярын Нямдулам	Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн дарга
Гишүүн	-	Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүн	Даваасамбын Сарангарал	Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүн	Сономсэмвийн Байгальмаа	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүн	-	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүн	-	Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
Гишүүн	Балдангийн Мөнхбат	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Гишүүн	Мусхаашийн Майжаргал	Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын хэлтсийн дарга
Гишүүн	Баятэрэн Оюутбоолд	Аймгийн Засаг даргын дэргэдэх Цэгдээгийн газрын дарга
Гишүүн	Нямдоржийн Бямбадорж	Аймгийн Мэргэжлийн хангалтын газрын дарга



1.1 Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, энэ талаар харьяалах байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байдал:

Аймгийн хэмжээнд төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор тус салбар зөвлөлөөс 2021 оныг **“ТӨРИЙН АЛБАНД ЁС ЗҮЙ, ЧАДАХУЙН ЗАРЧМЫГ**



ТӨЛӨВШҮҮЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАР ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ” жил болгон зарлаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгдүгээр хуралдаанаараа хэлэлцэн баталж, 92.6 хувийн биелэлтэйгээр хэрэгжилтийг зохион байгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.2, 5 дугаар зүйлийн 5.7-т заасан чиг үүргийн хүрээнд Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудад мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, хууль, тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор Салбар зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 08 дугаар тогтоолоор аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны болон үйлчилгээний 169 байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах удирдамж, чиглэл, үнэлж дүгнэх 8 шалгуур үзүүлэлтийг баталж, Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлагдсан удирдамжийн дагуу 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний хооронд 169 төрийн байгууллагад ажиллахаас 20 сумын 142 байгууллага буюу ажиллахаар төлөвлөсөн байгууллагын 84 хувьд хүрч ажиллав.




Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг хуралдаанаар хэлэлцүүлэн, салбар зөвлөлийн “Ажил эрчимжүүлэх тухай” 2021 оны 10 дугаар тогтоолоор төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлийг аймгийн 184 төрийн байгууллагад хүргүүллээ.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Төрийн албаны тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилт, Төрийн албаны Зөвлөлөөс гаргасан 18 удаагийн үүрэг чиглэл өгөх, судалгаа, мэдээлэл авах тухай албан бичиг ирүүлснийг тухай бүрт шийдвэрлэн ажиллалаа.



Тайлант онд Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийн хүрээн дэх төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн баталгаа, сургалт хөгжил, ёс зүйн зөрчил, сахилга хариуцлага, хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системийн бүртгэл, хөтлөлт, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зэрэг асуудлаар давхардсан тоогоор нийтдээ 10.000 гаруй төрийн албан хаагч, иргэдэд биечлэн, утсаар, албан бичгээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

1.2 Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах, энэ талаар үүрэг даалгавар, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал:

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, дүрэмд заасны дагуу 25-аас дээш албан хаагчтай байгууллагуудад “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах талаар салбар зөвлөлийн 2 удаагийн албан бичгийг хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Аймгийн 184 төрийн байгууллагын 97 нь ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллаж, байгууллагын дэргэдэх **Ёс зүйн зөвлөлүүд** нийт 123 удаагийн сургалт, зөвлөгөө, мэдээллийг **6387** төрийн албан хаагчдад өгч ажиллажээ.

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар байгууллагуудын Дотоод журам, Хамтын гэрээ, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн гэрээнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн 15 зөрчлийг тэмдэглэснээс уучлал гуйлгуулах шийтгэлийг 4, сануулах шийтгэлийг 5, албан тушаалаас чөлөөлсөн шийтгэлийг 1 албан хаагчид тус тус ногдуулжээ.

Албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлээгүй, ажлын сахилга, хариуцлага алдсан зэрэг шалтгаанаар 27 төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Салбар зөвлөл, Хууль эрх зүйн хэлтэс хамтран Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан **“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”**, **ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах** талаар 20 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, **364** төрийн албан хаагчдыг хамруулсан бол 12 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, **1800** гаруй төрийн албан хаагчдыг хамруулан, нийтдээ давхардсан тоогоор **184** төрийн байгууллагын **2228** албан хаагчдад сургалт, мэдээлэл хийсэн байна.

Төрийн албан хаагчид ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар давхардсан тоогоор **1000** гаруй төрийн албан хаагч, иргэдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

"ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА ЗӨВТЭЙ ТӨРИЙН АЛБА" САРЫН АЯНЫГ ӨРНҮҮЛЖ, ҮР ДҮНГ ДҮГНЭВ.

Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор "Өөрөө манлайлж, өөрөө үлгэрлэе" төрийн албан хаагчдын шинэ санал, санаачилгыг дэмжих, "Мэргэшсэн төрийн алба - Мэдлэг, чадвар, сэтгэлээр бэхжинэ" сэдэвт төрийн албан хаагчдын 3 үеийн уулзалт зохион байгуулах, "Чадварт тулгуурлаж, чанар хүртээмжтэй үйлчилье" гэсэн зорилтыг дэвшүүлэн Салбар зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор **"Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба"** сарын аяныг 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 11-ний хооронд зохион байгууллаа.



2021.10.11-11.11

"ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА ЗӨВТЭЙ ТӨРИЙН АЛБА" АЯН

Нэг сарын хугацаатай аяныг санаачлагч:
Төрийн албаны зөвлөлийн
Баянхонгор аймгийн салбар зөвлөл



Аяны хүрээнд 106 төрийн байгууллага идэвхтэй оролцсоноос **19** байгууллага "Чадварт тулгуурлаж, чанар хүртээмжтэй үйлчилье" шинэ санал санаачлага, ажлын бүтээмжээрээ хамт олноо манлайлсан албан хаагчаа хамт олноосоо шалгаруулан туршлагыг бусад албан хаагчдад сурталчилж, **28** байгууллага төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, **35** байгууллага ахмад, идэр, залуу 3 үеийн уулзалт, зөвлөгөөн зэргийг зохион байгуулж, төрийн албаны залгамж чанарыг хадгалах, идэр үеийн манлайлал, залуу үеийн санал санаачлагыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, түүнийгээ дүрсжүүлэн видео нэвтрүүлэг хийж, иргэд, олон нийтэд сурталчилж, **43** байгууллага албан хаагчдынхаа шинэ санал, санаачлагыг дэмжиж "Мэргэжил бүхэн сайхан" podcast, нэвтрүүлэг, видео зэргийг хийж төрийн албан хаагчийн ажил, мэргэжлийн онцлогийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, салбар зөвлөлөөс хүргүүлсэн **зөвлөмжийн** хэрэгжилтийг эрчимжүүлэн, зохион байгуулалтын олон ажлыг авч хэрэгжүүлсэн байна.

Аянд бусдыгаа манлайлан идэвх санаачлагатай оролцож, аяны хүрээнд тавьсан 3 зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн Биеийн тамир, спортын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Баян-Овоо сумын төрийн байгууллагууд, Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт, аудитын албаны хамт олон шилдгээр шалгарсныг



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Талархал, мөнгөн шагналаар урамшуулж, ажил үйлсээрээ манлайлсан төрийн албан хаагчдын “Төрийн албаны ахмад үе, дунд үе, залуу үе”-ийн төлөөллийг алдаршуулж, аймгийн төрийн захиргааны албан хаагчдын тоглолт хийж, төрийн албан хаагчдын урам зоригийг сэргээх, ажлын бүтээмжид нөлөөлөх ажлыг зохион байгууллаа.



1.3 Салбар зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэрлэлт:

Тус Салбар зөвлөл нь 2021 онд 8 удаагийн хуралдааныг хийж, эрх хэмжээний хүрээнд 25 асуудлыг хэлэлцэн 15 тогтоол шийдвэр гаргаж, хэрэгжилтийг 100 хувь зохион байгуулав.





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Салбар зөвлөлийн 2021 оны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын агуулга:



Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 2021 онд нийт 125 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, үүнээс орон нутгийн хэмжээнд Төрийн албаны тухай хууль, тогтоомж, төрийн албаны стандарт, Төрийн албаны

зөвлөлөөс гаргаж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн хариуг хүргүүлэх чиглэлээр 64, аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудад чиглэл хүргүүлсэн 36, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариуг хүргүүлсэн 25 албан бичгийг тус тус гаргалаа.


Тайлант хугацаанд 296 албан бичиг ирснээс хариутай 102 албан бичгийг 100 хувь шийдвэрлэж ажиллалаа.

Салбар зөвлөлд иргэдээс нийт 25 өргөдөл, гомдол ирүүлснийг хуралдаанаар хэлэлцэн 25 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, хариуг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувь байна.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлыг:



ШИЙДВЭРЛЭЛТ



Хоёр. Төрийн албаны нөөц бүрдүүлэх талаар:

2.1 Харьяалах байгууллагын “Хүний нөөцийн удирдлагын систем”-д мэдээлэл оруулж, төрийн байгууллагыг төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөхөд мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан байдал:

Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх журам”-ын дагуу тус салбар зөвлөлд харьяалагдах 179 төрийн байгууллага дээрх системийг хөтлөн явуулдаг.



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

		Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд сумдын төсөвт байгууллагууд болон аймгийн төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлын удирдамжийн 3 дугаар хавсралт				
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ						
Сумын нэр:						
Төрийн байгууллагын нэр: оны сарын						
Д/д	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлтэд өгөх оноо	Үнэлгээ		Авсан оноо	Тайлбар
1	Төрийн албан тушаалд тавих шаардлага хангасан иргэнийг бүртгэсэн байдал	5 оноо	Хангалттай	5		
			Хангалтгүй	0		
2	Цахим системийн нууцлалыг хангасан байдал	5 оноо	Хангалттай	5		
			Хангалтгүй	0		
3	Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр хийсэн байдал	5 оноо	Хангалттай	5		
			Хангалтгүй	0		
4	Төрийн албан хаагчийн мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулсан байдал	5 оноо	Хангалттай	5		
			Хангалтгүй	0		
5	Нийт	20 оноо				
Үнэлэх аргачлал:						
1.Төрийн албан тушаалд тавих шаардлага хангасан иргэнийг бүртгэсэн байдал гэсэн үзүүлэлтийг сүүлийн 1 жилийн байдлаар төсвөөс цалин, урамшуулал авч байгаа албан хаагч нь батлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байдлыг харгалзан үнэлнэ. 100 хувь шаардлага хангасан бол "Хангалттай" гэж үнэлнэ.						
2. Цахим системийн нууцлалыг хангасан байдал гэсэн үзүүлэлтийг системийн нэвтрэх нэр, нууц үгийг хариуцсан ажилтныг томилж, холбогдох журмын дагуу нууцлалын баталгаа гаргуулсан байдлыг харгалзан үнэлнэ. Тийм бол бол "Хангалттай" гэж үнэлнэ.						
3. Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр хийсэн бол "Хангалттай" гэж үнэлнэ.						
4. Төрийн албан хаагчийн мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулсан бол "Хангалттай" гэж үнэлнэ.						
5.Тайлбар хэсэгт тухайн үнэлгээ өгөх болсон нөхцөл шалтгааныг тодорхой тусгана.						
Төрийн байгууллагын бэлтгэх материал:						
1.Цахим системд нэвтрэх нэр, нууц үг;						
2.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг;						
3.Байгууллагын даргын Б тушаал;						
Үнэлгээ өгсөн: Ажлын хэсгийн гишүүн						
.....						
.....						

Салбар зөвлөл 2021 оны 05 дугаар хуралдаанаараа шийдвэр гаргаж, 08 дугаар тогтоолоор баталсан удирдамжийн дагуу харьяа байгууллагуудын Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлсөн байдлыг үнэлэх Төрийн албан тушаалд тавих шаардлага хангасан иргэнийг бүртгэсэн байдал, Цахим системийн нууцлалыг хангасан байдал, Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр хийсэн байдал, Төрийн албан хаагчийн мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулсан байдал гэсэн 4 шалгуур үзүүлэлтээр 179 төрийн байгууллагын цахим системд хүний нөөцийн мэдээллээ үнэн зөв, бүрэн оруулсан эсэхийг шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

2021 оны жилийн эцсийн байдлаар 112 байгууллага буюу 62,5 хувь нь цахим системийн нууцлалыг хангасан бол 67 нь буюу 37,4 хувь нь нууцлалыг бүрэн хангаагүй, 113 байгууллага буюу 63,1 хувь хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр хийсэн бол 66 байгууллага буюу 39.8 хувь





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

нь мэдээллээ тухай бүрт хийгээгүй байна. Төрийн албан хаагчийн мэдээллийг 98 байгууллага буюу 54.7 хувь нь үнэн зөв, бүрэн системд оруулсан бол 81 байгууллага буюу 45.2 хувь нь мэдээллээ үнэн зөв, бүрэн оруулаагүй байна.



“Хүний нөөцийн удирдлагын систем”-д мэдээлэл оруулж, төрийн байгууллагыг төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөх талаар Салбар зөвлөлийн 3 удаагийн албан бичгээр хугацаатай үүрэг чиглэлийг 184 төрийн байгууллагад хүргүүлж, биелэлтэд хяналт тавив.

Төрийн албаны улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх, хүний нөөцийн цахим системд мэдээлэл оруулах талаар 2021 онд нийт 179 төрийн байгууллагын давхардсан тоогоор 400 гаруй удирдах болон гүйцэтгэх албан хаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн, www.facebook.com /Баянхонгор Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтны групп чат, ТАЗ-ийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл гэсэн удирдах





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

ажилтнуудын групп чат/-аар тус тус мэдээллийг түгээн холбогдох асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Гурав. Төрийн албаны шалгалт зохион байгуулсан талаар:

3.1 Төрийн албаны Ерөнхий шалгалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байдал:

Төрийн албаны ерөнхий нөөц бүрдүүлэх шалгалтыг 2021 онд Төрийн албаны ерөнхий шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тов, чиглэлийн дагуу 3, 11 дүгээр сард 2 удаагийн шалгалтыг зохион байгуулж, 108 иргэний ерөнхий нөөцийг бүрдүүллээ.




2021 онд 2 удаагийн төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг зохион байгуулсан тухай



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ



Тус аймагт төрийн албаны ерөнхий шалгалтад орж, нөөцөд бүртгэгдэж буй иргэдийн шалгалтын онооны үзүүлэлт өмнөх оны дүнтэй харьцуулахад өссөн нь аймгийн хэмжээнд төрийн албаны ерөнхий шалгалтын мэдээллийн хүртээмж сайжирч, иргэдийн мэдлэг, мэдээлэл болон шалгалтад бэлдэж оролцох хандлага өөрчлөгдсөнийг доорх чанарын үзүүлэлт харуулж байна.





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Төрийн албаны шинэтгэлийн чухал

бүрэлдэхүүн хэсэг болох төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг олон талын оролцоотойгоор манлайлан, амжилттай зохион байгуулсан салбар зөвлөлийн нэгээр шалгарч, Төрийн албаны зөвлөлийн даргын **ТАЛАРХАЛ**, мөнгөн урамшууллаар шагнуулсан.



3.2 Төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийн байдал:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, Төрийн албаны зөвлөлийн 25 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу аймгийн 1 төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн боловч иргэний гаргасан гомдлоор цуцлагдсан.

2021 онд ТҮБТШЗ-ийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй талаар:




ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ



Салбар зөвлөлийн 2021 оны 106 дугаар албан бичгээр төрийн захиргааны байгууллагын туслах түшмэлийн 86 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, шалгалтыг 12 сарын 20-ны өдөр зохион байгуулан, 23 сул орон тоог нөхөхөөр салбар зөвлөлийн 2021 оны 15 дугаар тогтоолоор нэрийг дэвшүүлсэн.

2021 онд 1 удаагийн төрийн албаны сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулсан талаар:





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ



Тайлант оноос эхлэн сул ажлын байранд нэр нь дэвшигдэж, төрийн жинхэнэ албанд томилогдох шаардлагыг хангаж буй иргэн, тэднийг томилох эрх бүхий байгууллагын дарга нарыг салбар зөвлөлийн хуралд байлцуулж, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг чанд сахиж, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх, аливаа алдаа зөрчил гаргалгүй, төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөж ажиллахыг тухайн албан тушаалд нэр дэвшигчдэд, сул орон тоонд томилогдсон иргэдийн ажлын гүйцэтгэл үр дүнг хууль тогтоомжийн хүрээнд үнэлж дүгнэн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад анхаарч, сул болон зөрчилтэй томилгооны зөрчлийг арилгах, сум, байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллахыг

байгууллагын дарга нарт сануулж, зөвлөх ажлыг санаачлан зохион байгуулсан нь онцлог ажил боллоо.



Дөрөв. Сургалт, судалгаа, сурталчилгаа хийх талаар:

Төрийн байгууллага Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-т заасны дагуу төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2, 24, 29 дүгээр зүйл, 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх




ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

заалтад төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, мөн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн чадавхжуулах, ажлын байранд нь мэргэшүүлэх төлөвлөлтийг байгууллагын төсөвтэй уялдуулан хийж, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийн хүрээнд аймгийн 142 төрийн байгууллагын 73 нь буюу 51.4 хувь нь байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг баталж, 2021 онд 129 албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад, давхардсан тоогоор **8624** албан хаагчийг цахим болон танхимын хэлбэрээр чадавхжуулах сургалтад тус тус хамруулжээ.



Сүүлийн 4 жилийн байдлаар сургалт зохион байгуулсан байдал:





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ



Төрийн байгууллагуудын 48.6 хувь нь төрийн албан хаагчийн сургалтын нэгдсэн хөтөлбөр байхгүй, албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг батлахдаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 37/33 дугаар тушаалаар баталсан мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрт нийцүүлээгүй, төсөв төлөвлөж,

зарцуулаагүй, сургалтын үр дүнг тооцож, холбогдох арга хэмжээг авах эргэх холбоо байхгүй нийтлэг зөрчилтэй байгаад дүгнэлт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч 2022 оны төлөвлөлтөд тусгуулах ажлыг зохион байгууллаа.

Төрийн албаны тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч, иргэдэд сурталчлах зорилгоор тус салбар зөвлөлөөс 40 гаруй видео, нэвтрүүлэг, постер зэргийг бэлтгэн ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ цахим групп, аймгийн www.bayankhongor.gov.mn албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилж байна.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ



Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлаар зохион байгуулсан ажил, үр дүн, түүний хэрэгжилтийн талаар:

Төрийн байгууллагуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2021 онд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг дүгнэлээ. Нийт 184 төрийн байгууллагаас тайлан мэдээлэл ирүүлэхээс 135 байгууллагын тайланг хүлээн авч 73,3 хувийг хамрууллаа.

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага буюу 85,4 хувь нь байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 425,656,490 төгрөг, ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлээр 419,900.000 төгрөгийн санхүүжилтийг тус тус шийдвэрлэсэн байна.

Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс Улсын Их Хурлын “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам” батлах тухай 21 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу Төрийн захиргааны албан




ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

тушаалын зэрэг дэв олгох болзол шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгуулах саналыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлж байна.

Болзол, шаардлагыг хангасан 103 төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, саналыг аймгийн Засаг даргад уламжилж, аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.

Төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон байдал:




/сүүлийн 3 жилээр/

2021 онд зэрэг дэв олгосон байдал:



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ




Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах журамд заасан болзол, шаардлага хангасан төрийн захиргааны байгууллагад тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан 5 албан хаагчийг “Төрийн албаны Тэргүүний ажилтан” цол, тэмдэгээр шагнуулахаар уламжилж, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр 3 албан хаагчийг “Төрийн албаны Тэргүүний ажилтан” цол, тэмдэгээр шагнуулав.



Төрийн албаны тухай хууль, холбогдон гарсан журам, дүрэм, салбар зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг аймгийн www.bayankhongor.gov.mn цахим хуудас, [www.facebook.com/Баянхонгор аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл](https://www.facebook.com/Баянхонгор-аймаг-дахь-Төрийн-албаны-зөвлөлийн-салбар-зөвлөл) хаяг, салбар зөвлөлийн мэдээллийн самбарт байршуулан мэдээлэн ажиллаж байна.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ




Шинэлэг, онцлог зохион байгуулсан ажил:

1. "Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба" сарын аяныг өрнүүлж, үр дүнг дүгнэлээ.

Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн юм.

2. Төрийн албан хаагчдын дунд:

- гоцлол дуу
- Дуэт дуу
- Яруу найраг
- Ерөөл магтаал



Игт сарын хугацаатай явны саналчлагыг
Төрийн албаны зөвлөлийн
Баянхонгор аймгийн салбар зөвлөл

"ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА ЗӨВТЭЙ ТӨРИЙН АЛБА" АЯН

Аяны хүрээнд 19 байгууллага "Чадарт туугуулам, чандар хүртээмжтэй үйлчилгээ" шинэ санал санаачлагыг ажлын бүтээмжээрээ хамт олноо манлайсын албан хаагчаа хамт олноосоо шалгаруулан туршилыг бусад албан хаагчдад сурталчилжээ.

Аяны 28 байгууллага төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр оргилт, нөлөөллийн арга замыг зохион байгуулжээ.

ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА ЗӨВТЭЙ ТӨРИЙН АЛБА" сарын аяны хүрээнд байгууллууд салбар зөвлөлөөс хургуулсан зөвлөмжийн харагчидтай орчимжүүлэн зохион байгуулсан саналчлагыг авч харжүүлжээ.

"Мэргэсэн төрийн алба - Мэддэг чадвар, сэтгэлээр бэхжин" хөршгүй хүрээнд 28 байгууллагамаа, ирээдүйн үеийн уламжлалыг амжилтаар өргөжүүлжээ.





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

-Хөгжим

-Бүжиг зэрэг урлаг соёлын арга хэмжээг бэлтгэн 2 цагийн үнэ төлбөргүй тоглолтыг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Уг арга хэмжээ нь Салбар зөвлөлөөс санаачлан зохион байгуулсан “Ёс зүйн хандалага зөвтэй төрийн алба” аяны хаалтын үйл ажиллагаа бөгөөд төрийн алба, албан хаагчдын үнэ цэнэ, урам зоригийг сэргээх, ажлын бүтээмжид нөлөөлөх үр дүнтэй.




3. Орон нутагт Салбар зөвлөлийг бэхжүүлэх суурийг бүрдүүлэв.

Төрийн албаны шинэтгэлийг орон нутагт хэрэгжүүлэх, Салбар зөвлөлийг бэхжүүлэх зорилгоор аймгийн төсөвт Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх **65.0 сая** төгрөгийн төсвийг суулган батлууллаа. Дээрх төсвийг баталснаар:



➤ Төрийн албаны шинэтгэлийг орон нутагт хэрэгжүүлэх чухал бүрэлдэхүүн хэсэг болох төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгалтыг авах 20 зөөврийн компьютерийн асуудлыг шийдвэрлэж, 2022 онд нийлүүлэгдэх юм.



Шинэлэг
зохицуулалт

➤ Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч үйл ажиллагаанд зарцуулах төсвийг батлуулж, Салбар зөвлөлийг бэхжүүлэх суурийг тавилаа.

ХЯНАСАН
ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Б.НЯМДУЛАМ